

Бичиг баримтын бүрдлийг шалгах хуудас

/Дагнасан хэрэглээний зам, талбай барих - шинээр/

№	Бичиг баримтын жагсаалт	Тайлбар
1	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт бүхий албан бичиг	Зам, тээврийн яаманд хаяглана.
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	
3	Хуулийн этгээдийн үйл ажиллагааны танилцуулга /Дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар арчлалтын үйл ажиллагааг 3 жил зөрчил, дутагдалгүй гүйцэтгэсэн байх шаардлагатай/	Ажлын туршлага, хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалт, боловсон хүчний бүрэлдэхүүн, ажлын байр, засвар, үйлчилгээний үед мөрдөх технологийн горим, заавар зэрэг мэдээллийг агуулсан байх
4	Төмөр замын замын инженер – 1, геодези, зураг төслийн инженер – 1, замын техникч – 2, бусад мэргэжилтэй ажиллагсад /механикч – 1, замын мэргэжлийн ажилтан – 5/ нарын дараах баримт бичгийг ирүүлэх • Анкет • Мэргэжлийн диплом, мэргэжлийн зэрэг /нотариатаар баталгаажуулсан байна/ • Хөдөлмөрийн гэрээ • Ажилд томилсон тушаал • Нийгмийн даатгал	/Мэргэжилтэн 5-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан эсхүл мэргэшсэн инженер/
5	Харьяалах татварын байгууллагын тодорхойлолт	Татварын өргүй байна.
6	Харьяалах нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /НД лавлагаа, НД8 маягт/	Ажил олгогчоор бүртгүүлсэн, нийгмийн даатгалын тайлан гаргадаг, шимтгэлийн өргүй, мэргэжилтэн болон нягтлан бодогч нь нийгмийн даатгалд бүртгэлтэй, шимтгэл төлдөг байх
7	Хуулийн этгээдийн ажлын байрны талаарх мэдээлэл	Ажлын байр нь өөрийн эзэмшлийн бол үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ, түрээсэлдэг бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ
8	Багаж тоног төхөөрөмж хадгалах талбай, агуулахтай байх, эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих хэрэгсэл, цахилгаан хийн гагнуурын аппарат, замын индүү, усалгааны машин, авто самосвал, экскаватор, грейдер, замын димократ, цахилгаан чигжүүр, цахилгаан үүсгүүр, замын чиг татагч зэрэг тоног төхөөрөмжийн танилцуулга	Гэрэл зураг, баталгаажуулалтын гэрчилгээний хуулбар, эзэмшлийн мөн болохыг батлах баримт, хатуу тооцоот багажийг Тагнуулын ерөнхий газарт бүртгүүлсэн баримт, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт болон техникийн тодорхойлолт, тэдгээрийг ашиглах болох хүлээлцэх технологийн горим, зааврыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулан ирүүлэх.

Бичиг баримтын бүрдлийг шалгах хуудас

/ Дагнасан хэрэглээний зам, талбай барих - сунгуулах/

№	Бичиг баримтын жагсаалт	Тайлбар
1	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт бүхий албан бичиг /Гэрчилгээний хугацаа дуусахаас 21 хоногийн өмнө хүсэлт гаргасан байна/	Зам, тээврийн яаманд хаяглана.
2	Улсын бүртгэлийн гэрчилгээ	
3	Хуучин гэрчилгээний эх хувь	
4	Дагнасан хэрэглээний зам, талбай барих үйл ажиллагааны чиглэлээр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг захиалагчаар баталгаажуулан ирүүлэх	Сүүлийн 1 жилийн байдлаар
5	Харьяалах татварын байгууллагын тодорхойлолт	
6	Харьяалах нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /НД лавлагаа, НД8 маягт/	
7	Гэрчилгээ авахаар бүрдүүлж өгсөн материал болон мэдээлэлд орсон өөрчлөлтийн тухай мэдээлэл	Боловсон хүчний мэдээлэл, ажлын газрын мэдээлэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн танилцуулга, жагсаалт болон техникийн тодорхойлолт, тэдгээрийг ашиглах болох хүлээлцэх технологийн горим, зааврын дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ

<https://license.mrtd.gov.mn/login>